

## ТЭВЧИЖ БОЛОХ ЗАРДЛЫН САНАЛ

2020 оны 08 дугаар сарын 24-ний өдөр

1.Нэгдсэн төсвийн алдагдлыг Монгол Улсын засгийн газраас ОУВСан, Олон улсын бусад банк, санхүүгийн байгууллага болон хандивлагч зарим оронтой энэ оны 5 дугаар сард тохиролцсон хэмжээнд буюу ДНБ-ний -2.9 хувиас хэтрүүлэхгүй байх саналтай байна.

2.Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулах алхмыг хийж болохгүй. Учир нь гаднаас авах зээл, бондын хүү өсөх эрсдэлтэй. Ирэх оноос эхлэх бондуудын төлбөрийн зарим хэсгийг дахин зээл авах замаар төлөхөөр байна. Одоогийн байдлаар Монгол Улс өрийн ихээхэн дарамтанд орсон бөгөөд төсвийн алдагдал өөрөө Засгийн газрын өрийг улам бүр нэмэгдүүлж байгаа билээ. Үүний уршгаар Зөвхөн Засгийн газрын зээлийн хүүний үйлчилгээнд 1 их наяд орчим төгрөг буюу төсвийн нийт орлогын 10 хувийг төлж байна. Хэрэв төсвийн алдагдлыг ДНБ-ний 9.9 хувь буюу 3.8 их наяд төгрөг болговол 1.7 их наяд төгрөгөөр өрийг дахин нэмэгдүүлэхээр байна. Ингэснээр Монгол Улсын зээлжих зэрэглэлд асар их сөрөг нөлөөтэй болж Монгол Улсын санхүүгийн нөхцөл байдал, хамтын ажиллагаа хүндрэхэд хүргэнэ.

3.Монгол Улс валютын орлого нэмэгдүүлэхээс бусад импортыг бууруулах бодлогыг бүх түвшинд түүний дотор төсвийн байгууллагууд дээр чандлан хэрэгжүүлэх шаардлагатай. Үүний тулд бүх шатны төсөвт байгууллагуудын түлш, шатахууны зардлыг 40 хувиар, бичиг хэрэг импортын бүх зардлыг 20 хувиас доошгүй, төсвийн байгууллагуудад зориулсан бүх төрлийн тээврийн хэрэгсэл худалдан авах зардлыг доод тал нь 50 хувиар бууруулах саналтай байна. 2019 онд 168 тэрбум төгрөгийг түлш, шатахууны зардалд зарцуулсан байна. Эмийн үнийн өсөлтийг тогтоох механизм байхгүй, хөнгөлөлттэй эмийн жорыг бичих аргачлал тодорхой бус, эм өөрөө хүний эрүүл мэндэд холын үр дагавартай зэргийг бодолцон эмийн хөнгөлөлтийн механизмыг иргэдэд бодитой туслалцаа болох талаас нь цаашид боловсронгуй болгох шаардлагатай байна.

4.Монгол Улсад орлогын тэгш бус байдал газар авч нийгмийн бухимдал улам бүр нэмэгдлээ. Иймээс төсвийн зардлын бодлогод зарчмын шинэчлэл хийх нь зүй ёсны зорилт болж байна. Төрийн эрх барих болсон МАН-ын мөрийн хөтөлбөрийн үндсэн зарчим болсон дундаж давхаргыг нэмэгдүүлэх зорилтыг энэ оноос эхлэн хэрэгжүүлэхийг санал болгож байна. Тухайлбал, хавтгайрсан буюу баян ба дунджаас дээш орлоготой иргэдэд хамааралтай аливаа төсвөөс олгодог хөнгөлөлт, тэтгэмжийг аажмаар багасгаж нийгмийн дунджаас доош давхаргад чиглүүлэх шаардлагатай байна. Нийгмийн халамж гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа гэдгийг хуулиар тогтоон заасан. Уг нийгмийн халамжийн тэтгэмжийн нэг төрөл нь хүүхдийн мөнгөн тэтгэмж байдаг. Хуулийн дээрх заалтын хүрээнд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгодог боловч нийт хүүхдийг хамруулж хуулийн дээрх заалтыг зөрчсөөр байна. Одоогийн

байдлаар хүүхэд бүрт 100 мянган төгрөг олгож байгаа нь нэгдсэн төсвийн орлогынхоо **16.7** хувийг зөвхөн хүүхдийн мөнгөн тэтгэмжид олгож байгаа дүн гарч байна. Энэ нь бүхэл бүтэн боловсролын салбарт зориулж буй төсвийн нийт зардлаас ч өндөр байна. Төсвийн суурь зардал болох эмнэлэг, сургууль, нийгмийн халамж, цэрэг цагдаа, батлан хамгаалах гэх мэт төсвийн зайлшгүй зардлаа санхүүжүүлж чадахгүй байдалд ороход хүргэх эрсдэлтэй юм. Иймээс хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зардлыг бууруулж 2020 оны сүүлийн улиралд сар бүр 20 мянган төгрөг болгож олговол нийт дүнгээрээ 285 тэрбум төгрөгөөр 2020 оны төсвийн зардал буурч нэмж өр тавих явдал багасах болно. Жич: төсөв алдагдалтай болохоор аливаа зардлын нэмэгдэл нь жилийн 13-15 хувийн хүүтэй зээлийг авч санхүүжүүлэхэд хүргэнэ.

**5.Монгол Улсын нийт хөрөнгө оруулалтыг 244.0 тэрбум төгрөгөөс (Хавсралт №2)** доошгүй хэмжээгээр тодотгосон төсвөөс нэмж хасах нь зүйтэй. Ингэхдээ сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг байгууллагуудын техникийн чадавхийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг бууруулахгүйгээр ашиглалт муутай, хөдөө сумдад баригдахаар төлөвлөгдсөн барилгуудыг зогсоох, хувьчлах арга хэмжээ авах. Мөн 2000-аас доош хүн ам бүхий сумдад биеийн тамир, урлаг, спортын зэрэг төрийн үйлчилгээг тухайн сумдын сургуулийг түшиглэн зохион байгуулахаар төлөвлөж хөрөнгө оруулалтын бодлогод өөрчлөлт хийх. Мөн жилдээ 1-2 удаа цуглардаг багийн төв, үйлчилгээний байруудыг бариулах ажлыг зогсоох. Мөн сумдын захиргааны байр барих явдлыг түр хугацаанд зогсоох нь чухал байна. Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт өдгөө 30 гаруйхан хувьтай байгаа нь хөрөнгө оруулалт хэмнэгдэх, тэвчиж болох төсөл, арга хэмжээ олон байгааг харуулж байна. Эдгээртэй холбогдуулан төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээнүүдийн эдийн засгийн үр ашигт хөндлөнгийн мэргэжилтнүүд оролцсон судалгааны дүгнэлт гаргатай дээрх чиглэлийн хөрөнгө оруулалтыг хийхгүй байх.

Сүүлийн үед төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн сургууль, эмнэлэг, спорт заал, нийтийн орон сууц зэрэг барилга, байгууламж бараг жил хүрэхгүй хугацаанд эргэн засварт орж зардал улам бүр өссөөр байна. Иймээс их засварт 2019 оны гүйцэтгэлээр 27 тэрбум төгрөгийг зарцуулсан бол 2020 оны төсөвт 131 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвлөсөн байна. Бүтээмжтэй ажлын байрыг нэмэгдүүлж байж төсвийн орлогын баазыг нэмэгдүүлж төсвийг эрүүлжүүлэх эхлэл тавигдах учиртай.

Нэгдсэн төсвийн тодотголын зардлыг бууруулах дээр дурьдсан саналыг дүгнэн үзэхэд нийтдээ 673.3 тэрбум төгрөг болж байна. Хавсралт №1-д дурдсан эдгээр хэмнэгдэх зардлуудыг холбогдох салбарын болон санхүүгийн байгууллагууд сайтар тооцох шаардлагатай.

\*Зардал бууруулах саналын нэгдсэн тооцоолол. **(Хавсралт-1)**

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн зардал бууруулах саналын 1-р хавсралт

### ЗАРДАЛ БУУРУУЛАХ САНАЛЫН НЭГДСЭН ТООЦОО

(Тэрбум төгрөгөөр)

№	Утга	Тодотголын төсөлд тусгагдсан	ТТБЗ-ийн Санал буюу Тэвчиж болох зардал	Тайлбар
1	Түлш, шатахуун	85.3	34.1	40 хувиар бууруулах
2	Автомашин худалдан авах	4.9	2.5	Нийт 23 арга хэмжээ тусгагдсаныг 50 хувиар бууруулах
3	Сургуулийн хүүхдийн үдийн хоолны зардал	176.5	88.3	50 хувь бууруулах
4	Эмийн үнийн хөнгөлөлт	37.2	18.6	50 хувь бууруулах
5	Хөрөнгө оруулалтын тэвчиж болох зардал	3,408.6	244.0	Нийт 342 төсөл, арга хэмжээг хасах
6	Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100 мянган төгрөгийг он дуустал үргэлжлүүлэн олгох	357.3	285.8	Хүүхдийн мөнгийг 80 хувь бууруулах
			<b>673.3</b>	

### ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

--oOo--